



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/63

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.21, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 08 дугаар хуралдааны 4 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төр-Иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлж, төрийн зарим чиг үүргийг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлэх зорилгоор ажил гүйцэтгэх гэрээний дагуу “Би Монгол хүн” төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 40,000,000 (дөчин сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Зарцуулах хөрөнгийн тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас ажил гүйцэтгэх гэрээний дагуу санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Өнөрцэцэг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231018208